

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны 10 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2016 оны 10 дугаар сард Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 551 болж, 2015 оны мөн үеэс 567 хүнээр, өмнөх сарынхаас 59 хүнээр тус тус буурчээ.

Ажилгүйчүүдийн 45.37 хувь буюу 250 нь эмэгтэйчүүд байна. 2016 оны эхнээс 555 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 462 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 36.8 хувь буюу 170 нь эмэгтэйчүүд байв. Зураг I.1


Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 10 дугаар сарын эцсийн байдлаар, өссөн дүнгээр



Тайлант сард бүртгүүлсэн 157 ажилгүй иргэний 28.66 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 8.28 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 15.29 хувь нь орон тооны цомхтголоор; 15.92 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 1.27 хувь нь шилжин суурьшсан; 4.46 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 3.20 хувь нь байгууллага татан буугдсан; 5.73 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 1.27 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа

тэнцэхгүй болсон; 1.27 хувь нь цэргээс халагдсан; 8.28 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ. Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2016 оны 10 дугаар сарын эцэст



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 10 сард НДШ-ийн орлого 13.4 тэрбум ₮ болж төлөвлөгөө 98.71 хувь болж, төлөвлөгөөг 11 сум 2.65-30.1 хувиар давуулан биелүүлж. Архуст, Аргалант, Алтанбулаг, Баян, Баянхангай, Бүрэн, Батсүмбэр, Баянцагаан, Баянчандмань, Борнуур, Заамар, Мөнгөнморьт, Сэргэлэн, Эрдэнэ, Цээл, Зуунмод сумд 0.02-20.98 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 902.3 сая ₮ болж төлөвлөгөө 94.60 хувь болж төлөвлөгөөг Зуунмод сум 31.99 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжинд 33.4 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.7 хувийг өндөр настны, 10.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.7 хувийг

тэжээгчээ алдсаны, 5.1хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 270960 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 35.75 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 25.86%; тэтгэмжийн даатгалын сангийн 64.49%; эрүүл мэндийн даатгалын сангийн 98.59%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 73.83%; ажилгүйдлийн даатгалын сангийн 74.79%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 10 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 56293 хүнд олгож, 9.5 тэрбум ₮-ийг зарцуулж 2015 оны мөн үеэс хүний тоо 10.9 хувь 5566 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 29.4 хувь 2.2 тэрбум ₮-өөр тус бүр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 110850 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 40.88 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 24.83 хувийг халамжийн тэтгэвэр; 8.87 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 3.02 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 4.05 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 5.4 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.71 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




I.3 Эрүүл мэнд

2016 оны эхний 10 сард 13529 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.48 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 10 сард 1015 хүүхэд мэндэллээ.

Зураг I.3


Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар



Аймгийн хэмжээнд он гарсаар 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 12 хүүхдээр өслөө.

Зураг I.4


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар



2016 оны эхний 10 сард халдварт өвчнөөр 1037 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 4.64 хувь буюу 46 хүнээр өслөө. 2015 оны мөн үеэс заг хүйтэн 70 хувь, тэмбүү 64.04 хувь, трихомениаз 32.61 хувь, улаан бурхан 10,22 хувь тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 114 байгаа бол: Зуунмод 305, Баян-Өнжүүлд 176, Баян 163, Архуст 142, Угтаал 113, Сүмбэр 111 ногдлоо.

Зураг I.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар



1.4 Байгаль орчин

- агаарын дундаж температур нийт нутгаар 4.6 градус хүйтнээс 1.1 градус дулаан, Мааньтад 4,6 градус хүйтэн, Заамарт 1,1 градус дулаан байв.

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь 17-24 градус буюу Өндөрширээт орчмоор 24 градус хүрч дулаарсан байхад Мааньт, Байнжаргалан, Баянцагаан орчмоор арай сэрүүвтэр 17 градус дулаан байв.

-шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн бага температур нь 17-25 градус хүйтэн, Заамар, Бачнцагаан орчмоор харьцангуй дулаавтар -17 градус хүйтэн, нутгийн зүүн хойд хэсгээр хүйтэвтэр 24-25 градус хүйтэн байв. Сарын нийлбэр тунадас 0,6-17,7 мм байв. Үүнээс хамгийн бага нь Өндөрширээтэд 0,6 мм хамгийн их нь Зуунмодод 10,0 мм, Баянжаргаланд 10,8 мм, Мөнгөнморьтод 12,5 мм, Баянцагаанд 17,7 мм цас орсон байна. - Ихэнх хугацаанд 1-6 м/с салхитай, цас орох үеэр салхи 15, 24-25-нд 12-14 м/с, зарим газраар 16 м/с хүрч ширүүсэн, цас орж шуурлаа.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

2016 оны 10-р сард нойтон цас, цас нутгийн зүүн хэсгээр хэмжээний хувьд ахиу, бусад нутгаар орчим буюу бага орж, нийт нутгаар 1-р 10 хоногийн эхэн, 2-р 10 хоногийн ихэнх өдрүүдэдэд, 3-р 10 хоногийн эхээр харьцангуй дулаавтар, харин сарын дунд үеэс хүйтэрсэн байна. Агаарын дундаж, үнэмлэхүй бага температур өмнөх оноос хүйтэн, үнэмлэхүй их температур зарим газраар ойролцоо, ихэнх нутгаар хүйтэвтэр байлаа. 2015, 2016 оны 10-р сарууд нь салхи шуурга багатай хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хадлан тэжээл бэлтгэх, тариа ногоо хураах, өвөлжилтийн бэлтгэл хангах ажилд хүндрэл учруулаагүй байлаа. Цаг агаарын аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн салхи шуурга болоогүй.

2016 ОНЫ АРВАННЭГДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Төв аймгийн нутгаар: Агаарын температурын сарын дундаж нь ихэнх нутгаар 8-13 градус хүйтэн байдаг ба олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байна.

Дулаарах үе: Нэг болон хоёрдугаар арав хоногийн эхээр уулархаг нутгаар шөнөдөө 10-15 градус өдөртөө 2 градус дулаанаас 3 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 4-9 градус хүйтэн өдөртөө нутгийн өмнөд хэсгээр 7-12 градус бусад нутгаар 3-8 градус дулаан байна.

Хүйтрэх үе. Нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үе болон сүүлч, гуравдугаар арав хоногийн эхээр хүйтэрч, Туул, Тэрэлж голын саваар шөнөдөө 17-22 градус, өдөртөө 4-9 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 9-14 градус, өдөртөө 0-5 градус хүйтэн байна.

Хүйтний эрч чангарах үе: Гуравдугаар арав хоногийн сүүлийн хагаст хүйтний эрч чангарч, Туул, Тэрэлж голуудын сав дагуух нутгуудаар шөнөдөө 28-33 градус өдөртөө 17-22 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 20-25 градус, өдөртөө 10-15 градус хүрч хүйтрэх төлөвтэй.

Энэ сард Төв аймгийн баруун хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн дунд үе,

хоёрдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр нутгийн хойд хэсгээр, гуравдугаар арав хоногийн эхний хасагт зарим газраар цас орох төлөвтэй. Салхи нэгдүгээр арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар, хоёрдугаар арав хоногийн эхээр нутгийн өмнөд хэсгээр 16-18 м/с, гуравдугаар арав хоногийн эхний хасагт зарим газраар 12-14 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

11 дүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур нутгийн хойд болон төвийн хэсгээр олон жилийн дунджаас дулаан, өмнөд хэсгээр дунджийн орчим, хур тунадас нутгийн ихэнх хэсгээр дунджийн орчим, баруун болон төвийн нутгийн зарим газраар дунджаас ахиу, говийн нутгийн зүүн өмнөд хэсгээр дунджаас бага орох төлөвтэй байна. 10 дугаар сарын 20-ны байдлаар нийт нутгийн 70 гаруй хувьд цас орж, ихэнх нутагт 0-5 см, уулархаг нутгаар 11-15 см, зарим газартаа 23 см хүртэл зузаан цастай болсон байна. Цаашид 11 дүгээр сард ихэнх нутгаар цас ахиу орж, агаарын температур олон жилийн дунджийн орчим ба түүнээс дулаан байхаар байгаа нь цасан бүрхүүл тогтож, мөстөж хатууран малын хариулга маллагаа болон зам тээврийн ажилд таагүй нөлөөлж болзошгүйг анхаарна уу.



1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 10 сард аймгийн хэмжээнд 732 гэмт хэрэг бүртгэгдэж 760 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 3251.0 сая ₮-ийн хохирол учирлаа.

Гарсан гэмт хэргийн 35.3 хувь нь хулгай, 29.0 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний хэрэг, 14.9 хувь нь бусад хэрэг, 15.6 хувь нь замын осол, 4.4 хувь нь танхай дээрэм, 0.8 хувь нь хүн амины хэрэг тус бүр эзлэв.


Батсүмбэр, Заамар, Сэргэлэн, Аргалант, Борнуур, Баянжаргалан, Эрдэнэ, Жаргалант, Баяндэлгэр, Баянчандмань, Эрдэнэсант Алтанбулаг сумдад 10000 хүнд 391-90 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (81)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2015 оны мөн үеэс 27 хэргээр буурлаа.

Зуунмод суманд 37 эмэгтэй, 862 эрэгтэй нийт 899 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2015 оны мөн үеэс 74 хүнээр буурлаа.

Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар




Гарсан гэмт хэргийн 21.3 хувь нь бүлгээр 30.4 хувь нь согтуугаар үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 329 хүн гэмтэж 101 хүн нас барлаа.


Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар



Зураг I.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2016 оны эхний 10 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 820 гүйцэтгэх хуудсанд нийт 4.46 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 18 гүйцэтгэх хуудсанд ногдох 853.6 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 802 гүйцэтгэх хуудасны 3.59 тэрбум ₮-өөс 425 хуудасны 870.0 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 52.99 хувь, үнийн дүнгээр 24.22 хувь болж 2015 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 1.4 нэгжээр нэмэгдэж, үнийн дүнгийн биелэлт 4.19 нэгжээр буурлаа.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2016 оны эхний 10 сард кассын орлого 343.0 тэрбум ₮, кассын зарлага 345.2 тэрбум ₮ болж, гүйлгээнд 62.2 тэрбум ₮ байна.

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 151517, зээлийн багцын дүн 495.4 тэрбум ₮, зээл авсан зээлдэгчийн тоо 56415 олгосон зээлийн дүн 93.7 тэрбум ₮ боллоо.

Иргэдийн хувийн хадгаламжинд 10 сарын 31-ний байдлаар хугацаатай хадгаламж 37.4 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 12.2 тэрбум ₮ байна.

Иргэдийн харилцах дансны үлдэгдэл 10 сарын 31-ны байдлаар 207957 иргэний 8.96 тэрбум ₮ боллоо.

ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.3-1.39 хувь, хугацаатай доод хүү 0.50-0.60 хувь, хугацаагүй дээд хүү 0.08-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2016 оны эхний 10 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 10.8 тэрбум ₮, зарлага 55.2 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 112.93 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас; ХХОАТ, бусад орлого, бууны албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, ойгоос түлээ, мод ашигласны төлбөр, нохойн албан татвар, бусад төлбөр, хураамж, түрээсийн орлогын төлөвлөгөө биелэсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2015 оны мөн үеэс 10.4 хувь буюу 1.0 тэрбум ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 88.48 хувийг татварын, 10.96 хувийг татварын бус, 0.56 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2015 оны мөн үеэс татварын орлого 2.98 нэгжээр өсч, татварын бус орлого 1.96 нэгжээр, хөрөнгө борлуулсны орлого 1.0 нэгжээр тус бүр буурлаа.

Аймгийн нийт 3 шатны орлого 16.0 тэрбум ₮ болж аймгийнх 8.5 тэрбум ₮ буюу 53.29 хувь, сумынх 2.2 тэрбум ₮ буюу 13.88

хувь, улсынх 5.3 тэрбум ₮ буюу 32.89 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2015 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 37.5 хувь буюу 461.2 сая ₮-өөр буурч 768.2 сая ₮ болж, авлага 2.6 дахин буюу 382.0 сая ₮-өөр өсч 529.8 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 10.7 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 111.40 хувиар биелэгдлээ. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 2.2 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 144.81 хувь биелж, Баянхангай, Угтаал, Архуст, Борнуур, Сүмбэр, Эрдэнэсант, Заамар, Баян, Баянцогт, Дэлгэрхаан, Эрдэнэ, Аргалант, Батсүмбэр, Баянжаргалан, Цээл сумд 59.87-0.32 хувиар тасалдууллаа. Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 8.5 тэрбум ₮ болж 106.83 хувь биелж Угтаал, Жаргалант, Баянцогт, Баянцагаан, Сүмбэр, Эрдэнэ, Эрдэнэсант, Баянжаргалан, Борнуур, Баянхангай, Баян, Цээл, Аргалант сумд төлөвлөгөө 36.09-0.34 хувиар тасалдууллаа.



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2016 оны 10 дугаар сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 63.55%, өмнөх оны мөн үеэс 3.02%-аар тус тус өсч, өмнөх сараас 0.59 хувиар буурав. ХҮИ-ийн 10 дугаар сарын 0.59 хувийн бууралтад хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 0.66 нэгж буурсан нь голлон нөлөөлөв.

Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



ХҮИ өмнөх оны мөн үеэс 3.02% өссөний дотор хувцас бөс бараа гутлын бүлэг 5.63%; бусад бараа, үйлчилгээний бүлэг 10.31%; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 5.29%; гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 4.54%; тээврийн бүлэг 4.12%; орон сууц, ус цахилгаан, хийн түлшний бүлэг 3.78%; амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 1.34%; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 0.67%; эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 0.16%-аар тус тус өсч, хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 0.68% холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 4.18%-аар тус тус буурав. Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ тогтвортой байв.

Бүгд	2016 оны 10 сард	
	пунктээр	хувиар
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	-0.86	111.16%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.00%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	-0.01	1.37%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮҮШ	0.00	0.00%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.03	-4.96%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	0.00	0.00%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.04	-7.57%




II.5 Аж үйлдвэр

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2016 оны эхний 10 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 40.78 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2015 оны мөн үеэс 13.8 хувь буюу 4.93 тэрбум ₮-өөр өслөө.

Зураг II.6Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, оны үнээр, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2015 YII	2016 YII	2015 I-YII	2016 I-YII	Дүнд зэлэх % Percentage share to total		2016% 2015%
					2015-I-YII	2016-I-YII	
Нийт дүн	9,927.14	6,689.37	35,851.97	40,782.98	100.0	100.0	113.8%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	9,336.13	6,326.55	30,117.31	36,141.57	8400.46%	88.62	120.0%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	496.83	224.32	4,579.43	3632.70	12.77	8.91	79.3%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	94	138.50	1,155.24	1,008.71	3.2	2.47	87.3%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, хувцас үйлдвэрлэл, модон эдлэл үйлдвэрлэл, ус хариутгал хангамж үйлдвэрлэл өмнөх оноос 3.5 дахинаас 0.17 хувь буюу 6.04 тэрбумаас 3.25 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.



Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Жаргалант, Баянчандмань, Зуунмод, Баянцогт, Баянцагаан, Эрдэнэ, Батсүмбэр, Баян, Угтаалцайдам сумд 42.76-0.25 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 98.55) хувийг эзлэв.

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, хувиар



II.6 Барилга

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2016 оны эхний 10 сард 3.6 тэрбум ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2015 оны мөн үетэй харьцуулахад 25.82 хувь буюу 1.2 тэрбум ₮-өөр буурав.


Барилга угсралт, их засварын ажлын 65.94 хувь нь орон сууцны бус барилгад; 23.13



хувь нь инженерийн барилга байгууламжид; 10.92 хувь нь орон сууцны барилгад ногдож байна. Энэ нь 2015 оны мөн үетэй харьцуулахад орон сууцны бус барилгын ажил 31.66 пунктээр, орон сууцны барилгын ажил 5.88 пунктээр тус тус өсч, инженерийн барилга байгууламжийн ажил 37.55 пунктээр буурав.

Зураг II.8

Барилга угсралт, их засварын ажил жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, тэрбум.₮




II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 10 сард 152.1 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 69.3 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.11 хувь буюу 27.0 сая ₮-өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 86.6 сая ₮ болсон ба нийт орлогын 90.52 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 18.57 хувийг албан бичгийн, 94.94 хувийг зорчигчдын, 13.51 хувийг бусад орлого бүрдүүлжээ

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 10 сард нийт 996 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 19; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 560; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 3; бэлэглэлийн гэрээ 14; худалдах, худалдан авах гэрээ 46; өв залгамжлал 7; барьцааны гэрээний бүртгэл 143; бусад бүртгэл 203 тус бүр бүртгүүлээ.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2016 оны эхний 10 сард нийт 105 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани/ХХК/ 64; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 16; шашин 3; боловсрол сургалтын байгууллага /БСБ/1; гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 6; үйлдвэрчний эвлэлийн байгууллага /ҮЭБ/ 4; Төсөвт 5; Хоршоо 4; бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл /ББН/1; хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл /ХХН/ 1; орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар/ОНӨААТҮГ/ 1 тус бүр бүртгүүлээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2016 оны 10 сарын мэдээгээр 188 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 54; гишүүн нэмэгдсэн, хасагдсан 23; дүрэм шинэчилсэн 4; дахин гэрчилгээ 8; удирдлага өөрчлөгдсөн 28; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 15; дүрмийн сан нэмэгдсэн, хасагдсан 21; хаяг өөрчлөгдсөн 2; нэр хэлбэр өөрчлөгдсөн 17; татан буугдсан 16; тус бүр бүртгүүлээ. Мөн

50 иргэн, 18 хуулийн этгээдэд лавлагаа олголоо.

Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2016 оны эхний 10 сарын мэдээгээр нийт 287 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 503; үүнээс тохирлын гэрчилгээ 433, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 70; хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 3568; үүнээс цулын хэмжүүр 689, жин 594, туухай 82, автомашины жин 13; эзэлхүүн зарцуулалтын хэмжүүр 226; үүнээс түгээгүүрийн хэмжүүр 226, мерник 16, шингэн бүтээгдэхүүнийг хэмжих хэрэгсэл 12, сүмбэн метр 36, уртын хэмжих хэрэгсэл 13, усны тоолуур 85; нэг фазын тоолуур 2469, дулаан даралт 22, даралтны аппарат 5 тус бүр баталгаажуулсан байна.